



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 51

Хөхээр

"Арвайхээр тохижилт, үйлчилгээ" Орон нутгийн  
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар  
байгуулж, дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 18.1.3-ын "в", "ж", 18.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2. "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөөлөн удирдах зөвлөлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж, үйл ажиллагаанд хяналт тавин ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч (О.Пүрэвдорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ДАМАРТҮВШИН



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 2 дугаар сарын  
16-ны өдрийн 24 дугаар тогтоолын хавсралт

## **"АРВАЙХЭЭР ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ" ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэхэд үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан ажил үйлчилгээ эрхлэх орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн.

1.2 "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь (цаашид "орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар" гэх) нь үйл ажиллагаандаа Монгол Улсын "Иргэний хууль", "Хөдөлмөрийн тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай", "Хог хаягдлын тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3 Тус дүрмийн зорилго нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх, ашиглах зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4 "Арвайхээр тохижилт үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өмчлөгч нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал байх бөгөөд төлөөлөн хэрэгжүүлэгч нь Арвайхээр хотын Захирагчийн алба байна.

### **ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР**

2.1 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын оноосон бүтэн нэр нь "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байх бөгөөд товчилсон нэр нь "Арвайхээр ТҮ" ОНӨААТҮГ байна.

2.2 Арвайхээр тохижилт үйлчилгээний оршин байгаа газар нь: Өвөрхангай аймаг Арвайхээр сум, 5-р баг.

### **ГУРАВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БИЛЭГДЭЛ ТЭМДЭГ**

3.1 "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ нь өөрийн билэгдэл, барааны тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

3.2 Билэгдэл, барааны тэмдгийн загварыг гүйцэтгэх захирал баталж, Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг Арвайхээр ОНӨААТҮГ эдэлнэ.


3.3 Тэмдгээр "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ албан ёсны шийдвэр, албан бичиг гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4 Тэмдгийг "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

### **ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**



4.1 Арвайхээр тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын зорилго нь Арвайхээр хотын нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, нохой устгал, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, хог тээвэрлэлт, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг хариуцах үйл ажиллагааны тогтвортой, тасралтгүй байдлаар хангахад оршино.



4.2 "Арвайхээр тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ нь дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

4.2.1 Авто зам, замын байгууламжийн цэвэрлэгээ, арчлалт болон өвлийн улиралд авто, явган замын цас, мөсийг цэвэрлэх, нөөц бүрдүүлэх, орчны аюулгүй байдлыг хангах

4.2.2 Хог хаягдлын ачилт, тээвэрлэлт, нэгдсэн хяналт

4.2.3 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хариуцах ландшафлын аргаар дарж булшлах

4.2.4 Золбин нохой, муурын устгалын ажлыг хэрэгжүүлэх, татвар хураамжийг төвлөрүүлэх

4.2.5 Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхлэх

4.3 Болзошгүй аюул аваар ослын үед хүн хүч, техникийн нөөцийн шуурхай зохицуулалт хийх

4.4 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь гадаад дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцоно.

4.5 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбай, автозам, барилга байгууламж, эд аж ахуйг шинээр барих, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад хүлээн авахад оролцож, саналаа илэрхийлэн акт, баримт бичигт холбогдох этгээд гарын үсэг зурна.

4.6 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь өөрийн эрхлэх үндсэн үйл ажиллагааг өмчийн бүх төрлийн хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

4.7 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь үйлдвэрлэлийн болон тээвэр үйлчилгээний баазын материаллаг баазыг өргөтгөх, орчин үеийн тусгай зориулалтын шинэ техник технологийг нэвтрүүлэх, хүчин чадлыг нь бүрэн ашигласан үйлдвэрлэл үйлчилгээ явуулна.

4.8 Үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг хотын Захирагчийн албанд уламжлах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

4.9 Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд Арвайхээр тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

#### ТАВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 ОНӨААТҮГ нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээнэ.

5.2 ОНӨААТҮГ нь эд хөрөнгийн талаар дараах эрхтэй байна.

5.2.1 ОНӨААТҮГ нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээнэ.

5.2.2 ОНӨААТҮГ нь эд хөрөнгийн талаар "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй.



5.2.3 ОНӨААТҮГ нь үндсэн хөрөнгийг зөвхөн аймгийн, сумын захирал, захиралын шийдвэрийг үндэслэн акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах шилжүүлэх эрхтэй.

### ЗУРГАА. АРВАЙХЭЭР ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН УДИРДЛАГА, УДИРДАХ ЗӨВЛӨЛ



6.1 ОНӨААТҮГ-ын эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүдийг 5-аас доошгүй бүрэлдэхүүнтэйгээр хотын Захирагчийн албнаас санал оруулж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид томилж, байгуулна.

6.1.1 Хотын Захирагчийн алба нь орон нутгийн өмчийн төлөөлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, өөрчлөх талаар сумын Засаг даргын саналыг боловсруулж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр шийдвэрлүүлэх, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах, туслах ажлыг хариуцна.

6.1.2 ХЗАлба нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн эрх шилжүүлсэн 2019 оны 94 дүгээр шийдвэрийг хэрэгжүүлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 3.4 дэх хэсгийн утгыг баримтлан санал боловсруулж, хэлэлцүүлнэ.

6.1.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хурлыг Төлөөлөн удирдах зөвлөл байгуулсанаас хойш нэг сарын дотор хуралдуулах ажлыг зохион байгуулна.

6.1.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдааныг явуулахдаа Компанийн тухай хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө.

6.1.5 Төлөөлөн удирдах зөвлөл нь орон нутгийн өмчийн төлөөллийн эрх хэмжээ, ажиллах журмыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулна.

6.1.6 Төлөөлөн удирдах зөвлөл нь Компаний тухай хуулийн 78.1-ийг баримтлан Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгоно.

6.1.7 Төлөөлөн удирдах зөвлөл нь ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоог батлаж, цалин хөлсний болон үйлчилгээний норм, нормативыг бодитой тогтооход удирдан чиглүүлэх, тухайн жилд хийгдэх ажлын болон их засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийн тооцоог хэлэлцэх, холбогдох хууль, журамд нийцүүлж батлах, батлуулах.

6.1.8 Зайлшгүй нэмэлтээр хөрөнгө оруулалт хийх тохиолдолд саналаа тооцоо, судалгаатайгаар боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна.

6.1.9 ТУЗ-ын гишүүд нь гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар дамжуулан өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримт, тайлан мэдээлэл зэргийг аман болон бичгээр авна.

6.1.10 ОНӨААТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдана. Гүйцэтгэх захирлыг Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагчийн захирамжаар томилж, чөлөөлнө.

6.2. Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэм болон хотын Захирагчийн албаны ерөнхий менежертэй байгуулсан "Контракт"-нд заасан эрх хэмжээний хүрээнд үйлдвэрийн газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

6.3. Захирал нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

6.3.1 Гүйцэтгэх захирал нь Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь шалгуурыг хангасан байна.

6.3.2 Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх.

6.3.3 Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан удирдлагын бүтэц, ТУЗ-өөс баталсан орон тоо, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, батлах, ажилтныг томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалингийн хэмжээ, урамшууллын журам тогтоох, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх.

6.3.4 Төрийн албаны тухай хуулийн дагалдах журмууд болох Засгийн газрын шийдвэрүүдтэй нийцүүлж "Байгууллагын дотоод журам" боловсруулан, ажиллагсдын цалин хөлсний норм, нормативыг тогтоох, нийгмийн баталгааг хангаж ажиллана.



6.3.5 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх хариуцлага хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэрэг асуудлыг хөдөлмөрийн гэрээнд тусгана.

6.4 Гүйцэтгэх захирал нь аймаг, сумын Засаг дарга, хотын Захирагчийн албанаас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, удирдах газрыг төлөөлөх зэргээр удирдах газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

6.5 Гүйцэтгэх захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

6.6 Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг.

6.7 Гүйцэтгэх захирал нь өөрийн эрх үүргийг хотын Захирагчийн Албаны ерөнхий менежертэй зөвшилцөн итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **ДОЛОО. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ**

7.1. Арвайхээр тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг захирал батална.

7.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

7.3. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

### **НАЙМ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН САНХҮҮ, БҮРТГЭЛ, ТАЙЛАН**

8.1 Арвайхээр тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргаж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.2 Газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

8.3 Газрын нягтлан бодогч нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байна.

8.4 Газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөн оны 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.

### **ЕС. АРВАЙХЭЭР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

9.1 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

9.1.1 Улс, Аймаг, орон нутгийн төсвийн санхүүжилт

9.1.2 Үндсэн үйл ажиллагааны орлого

9.1.3 Олон улсын байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олох үйлчилгээний орлого;

9.1.4 Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

9.2 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

9.2.1 Баланс

9.2.2 Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

9.2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

9.2.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан

9.2.5 Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин шагнал урамшуулал



**АРВАН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫГ ӨӨРЧЛӨХ, ТАТАН БУУЛГАХ**



10.1 Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагчийн саналаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрдэнэ.

**АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА**

11.1 Монгол Улсын хууль тогтоомж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагчийн захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

**АРВАН ХОЁР. БУСАД**

12.1 Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

12.2 ОНӨААТҮГ-ын энэхүү дүрэм нь Монгол Улсын "Улсын бүртгэлийн ерөнхий газар"-ын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.